


**ҮНДЭСНИЙ
ХУВЬЧЛАЛЫН
САН**



**2020 ОНЫ
ЖИЛИЙН ТАЙЛАН**

ЭРХЭМ ХҮНДЭТ ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ ТАНАА

2020 он Монгол Улс төдийгүй Дэлхий нийтийн хувьд эрүүл мэнд болон эдийн засгийн томоохон сорилттой тулгарсан жил байлаа. Монгол Улс хэд хэдэн удаа хөл хорио тогтоож, хилээ хааснаар эдийн засаг огцом уналтад орсон хэдий ч Үндэсний Хувьчлалын Сан хамтын ХОС нь 2020 онд амжилттай хөрөнгө оруулалтууд хийж ажилласныг дуулгахад таатай байна.

2020 оны сүүлээр Үндэсний Хувьчлалын Сан нь хөрөнгийн зах зээлд хөрөнгө оруулалт хийж, өгөөж хүртэх сонирхолтой иргэдэд цоо шинэ хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн болох нэгж эрхийг санал болгосноор ард иргэдээсээ 4.75 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтыг амжилттай татсан билээ. Ингэснээр салбартаа анхдагч нь байж, Монгол Улсад хамтын хөрөнгө оруулалтын сан үүсэх үндэс суурийг тавилаа.

Монгол улсын эдийн засгийн хувьд 2020 онд ДНБ дөрөвдүгээр улирлын байдлаар оны өмнө үеэс 5.3%-иар агшсан, улсын инфляц 2.3% болсон нь Монголбанк бодлогын хүүгээ 6%-д хүргэн бууруулж, эдийн засгийг дэмжих бодлого хэрэгжүүлэхэд дөхөм боллоо. Бодлогын хүү түүхэн доод хэмжээнд хүрсэн нь банкуудын зээл болон хадгаламжийн хүүг огцом буурах үндсэн нөхцөл болов. Хадгаламжийн хүү буурч, хөрөнгө оруулагчид хөрөнгө оруулалтын өгөөжтэй хэрэгсэл хайж эхэлсэн энэ цаг үед Үндэсний Хувьчлалын Сангаар дамжуулан хөрөнгө оруулалт хийх боломж гарч ирсэн нь хөрөнгө оруулагчдын хувьд ихээхэн ач холбогдолтой байв.

Үндэсний Хувьчлалын Сан нь ард иргэдээс татан төвлөрүүлсэн хөрөнгөөр үр ашигтай хөрөнгө оруулалтууд хийж, 2020 оны 12 сарын 31-ний өдрийн

байдлаар хөрөнгө оруулагчдадаа 8.63%-ийн өсөлтийг үзүүлжээ. жилийн 25.6%-ийн өгөөжтэй ажиллаж чадсан байна. Ингэснээр Үндэсний Цаашид Үндэсний Хувьчлалын Сан Хувьчлалын Санд хөрөнгө оруулалт нь 2020 оны үр дүнгээ бататгаж, хийсэн хөрөнгө оруулагчид жилийн 2021 ондоо олон улсын зах зээл дэх 25.6%-ийн өгөөжтэй хөрөнгө хувьцаа болон өрийн хэрэгслүүдэд оруулалтын багцыг эзэмшиж хөрөнгө оруулахад түлхүү анхаарч, байгааг дуулгахад таатай байна. Нью-Йоркийн хөрөнгийн бирж, Түүнчлэн Сангийн нэгж эрхийг анх Хонг-Конгийн хөрөнгийн бирж дээр хөрөнгө оруулагчдад 100 төгрөгөөр нээлттэй арилжаалагддаг үнэт санал болгож байсан бол 2020 оны цаасанд голчлон хөрөнгө оруулалт жилийн эцсээр 108.63 төгрөгөөр хийж, хөрөнгө оруулалтынхаа өгөөжийг арилжаалагдаж, 2 сарын хугацаанд нэмэгдүүлэхээр ажиллах болно.

Гүйцэтгэх захирал

Ч.Хандаа

ТАНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САНГИЙН ГҮЙЦЭТГЭЛ

- Үндэсний Хувьчлалын Сан хамтын ХОС нь үйл ажиллагаа явуулж эхэлснээс хойш өнгөрсөн 2 сарын хугацаанд дотоодын зах зээлд голлон хөрөнгө оруулалт хийж ажилласан бөгөөд нийт 4.42%-ийн өгөөжтэй буюу жилээр тооцвол хүлээгдэж буй өгөөж 25.6% болсон байна. Энэ нь бидний зорьж байсан дундаж хөрөнгө оруулалтын өгөөж болох 17.6%-ийн өгөөжөөс 8 нэгжээр өндөр үзүүлэлт юм.
- Монголын хөрөнгийн зах зээлийн хувьд 2020 онд 1.7%-ийн уналттай байв. Өөрөөр хэлбэл, Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн хувьцааны өсөлт бууралтыг харуулдаг ТОП-20 индекс 2020 оны 12 сарын 31-ний өдрөөр 19,285.8 нэгжид хүрч, өмнөх оны мөн үеэс 1.7%-иар буурсан байна.
- Монголбанк бодлогын хүүгээ түүхэн доод хэмжээнд бууруулж, 6%-д хүргэсэн нь банкуудын зээл болон хадгаламжийн хүүг огцом бууруулах үндсэн нөхцөл болов. 2020 оны 12 сарын байдлаар банкуудын шинээр татсан жилийн хугацаатай хадгаламжийн хүү 11.3% байв.

Хөрөнгө оруулалтын хэрэгслүүдийн өгөөжийн харьцуулалт

	2017	2018	2019	2020
Үндэсний Хувьчлалын Сангийн хөрөнгө оруулалтын өгөөж				25.6%
ТОП-20-ийн өгөөж	66.5%	3.5%	-8.6%	-1.7%
Хадгаламжийн хүү	15.8%	14.1%	13.5%	11.3%

Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж, Монголбанк

ҮНДЭСНИЙ ХУВЬЧЛАЛЫН САНГИЙН ТОВЧ ГҮЙЦЭТГЭЛ

Тикэр

ХОС

Гаргасан нэгж эрх

50 сая ширхэг

Нэгж эрх эзэмшигчийн тоо

2,451

Нэгж эрхийн хаалтын ханш

₮108.63

Зах зээлийн үнэлгээ

₮5.43 тэрбум

Өдрийн дундаж арилжаа

₮6.98 сая

Нэгж эрхийн NAV

₮104.42

Нийт цэвэр хөрөнгө NAV

₮5.22 тэрбум

Дэлгэрэнгүй орлого

₮220.85 сая

ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Сангийн мэдээлэл

Үндэсний Хувьчлалын Сан хамтын хөрөнгө оруулалтын сан нь Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан хуулийн этгээдийн эрхтэй, тусгай зориулалтын компани юм.

Нэр	Үндэсний Хувьчлалын Сан хамтын хөрөнгө оруулалтын сан
Сангийн хэлбэр	Хаалттай хамтын хөрөнгө оруулалтын сан
Үйл ажиллагаа	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа эрхлэх
Хугацаа	Үүсгэн байгуулагдсан хугацаа: 2019-8-7 Үйл ажиллагаа явуулах хугацаа: 10 жил
Сангийн татан төвлөрүүлсэн хөрөнгө	5,000,000,000 төгрөг
Хөрөнгө итгэмжлэн удирдах компани	"Ард Менежмент ҮЦК" ХХК
Хөрөнгө хадгалах компани	"Голомт Банк" ХХК-ийн кастодиан банкны хэлтэс
Хаяг	- Монгол Улс, СБД, Ерөнхий Сайд Амарын гудамж, "Ард Санхүүгийн Нэгдэл" ХК-ийн байр, 2 давхар - Утас: 976-11-70078080 - И-мэйл: info@ardmanagement.mn - Вэб сайт: ardmanagement.mn

Сангийн зорилго

Сан нь Монгол Улс болон дэлхий даяар арилжаалагддаг үнэт цаасанд хөрөнгө оруулалт хийн, түүнээс бий болох ашгийг хөрөнгө оруулагчдадаа хуваарилахаар зорьж ажилладаг. Сангийн зорилго:

- Улс орны эдийн засагт томоохон байр суурь эзэлдэг төрийн өмчит компаниудын хувьчлалд оролцож, компанийн үйл ажиллагааг өргөжүүлэх, үнэлгээг өсгөх замаар урт хугацаанд өгөөж хүртэх;

- Дунд хугацаанд Үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй нээлттэй хувьцаат компанийн хувьцаа, бондод хөрөнгө оруулалт хийж, өгөөж хүртэх;
- Мөнгөн урсгал, хөрвөх чадварыг тогтвортой байлгаж, эрсдэлийг багасгахын тулд засгийн газрын үнэт цаас, банкны хадгаламж зэрэг тогтмол орлоготой хөрөнгө оруулалтын хэрэгслүүдэд хөрөнгө оруулалт хийн өгөөж хүртэх.

Хөрөнгө оруулалтын бодлого

Үндэсний Хувьчлалын Сан нь хөрөнгө оруулалтын бодлогын хүрээнд тооцоо судалгаа хийсний үндсэн дээр хөрөнгө оруулалт хийдэг бөгөөд сангийн нийт хөрөнгийн 70 хүртэлх хувиар дотоод болон гадаадын хөрөнгийн зах зээлд бүртгэлтэй хувьцаат компанийн хувьцаанд хөрөнгө оруулалт хийж ажилладаг. Ингэхдээ компанийн суурь шинжилгээ, зах зээлийн судалгаа зэргийг багтаасан мэргэжлийн судалгаа шинжилгээнд үндэслэн хөрөнгө оруулалт хийдэг болно.

НЭГЖ ЭРХ ЭЗЭМШИГЧДИЙН БҮТЭЦ

Үндэсний Хувьчлалын Сан нь 2020 оны 10 сарын 5-ны өдөр анх олон нийтэд нэгж эрхээ санал болгон арилжаалсан бөгөөд ард иргэдээсээ 4.75 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтыг амжилттай татсан билээ. Ингэхдээ санал болгосон үнийн дүнгээс 33%¹ -иар захиалга давж биелсэн тул нийт 2,245 хөрөнгө оруулагчдад Сангийн нэгж эрхийг хувь тэнцүүлэн хуваарилж байсан. Өнгөрсөн 2 сарын хугацаанд Сангийн нэгж эрх эрэлттэй байсан нь хөрөнгө оруулагчдын тоог нэмэгдүүлж, 2020 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар Сан нь нийт 2,451 нэгж эрх эзэмшигчтэй болсон байна.

Нэгж эрх эзэмшигчдийн бүтэц


Нэгж эрх эзэмшигч	Нэгж эрхийн тоо	Хувь
Ард Даатгал ххк	6,496,056	12.99%
А.Тулга	3,000,000	6.00%
Ард Кредит ББСБ ХХК	2,977,145	5.95%
Жи Эс Би Капитал ББСБ ХХК	2,500,000	5.00%
Ард Менежмент ҮЦК ХХК	2,500,000	5.00%
М Си Эс Инвестмент ХХК	2,500,000	5.00%
Бусад 2445	30,026,799	60.05%
Нийт	50,000,000	100.00%

¹ Жижиглэн хөрөнгө оруулагчдад санал болгон үнийн дүнгээс давсан үзүүлэлт

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГҮЙЦЭТГЭЛ


Үндэсний Хувьчлалын Сан хамтын ХОС нь 2020 оны 10 сарын 30-ны өдөр Санхүүгийн Зохицуулах Хорооноос тусгай зөвшөөрөл авч, үйл ажиллагаагаа эхэлсэн билээ. ХОС нь өнгөрсөн хугацаанд дотоодын зах зээлд голлон хөрөнгө оруулалт хийж ажилласан бөгөөд 2020 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар нийт 220.9 сая төгрөгийн ашигтай (татвар төлсний дараа) ажиллаж, цэвэр активын үнэлгээ (NAV нь нийт активаас нийт өр төлбөрийг хассан дүн) 5,220.9 сая төгрөгт хүрлээ. Ингэснээр хөрөнгө оруулагчдадаа жилийн 25.6 хувийн өгөөжтэй буюу өнгөрсөн 2 сарын хугацаанд 4.42%-ийн өгөөжтэй хөрөнгө оруулалт хийсэн байна.

Сангийн нэгж эрхийн хаалтын ханш болон нэгж эрхийн үнэлгээ




Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж

Тайлант хугацааны туршид сангийн хөрөнгийн бүтцийн өөрчлөлт



Эх сурвалж: Ард менежмент ҮЦК ХХК

Тайлант хугацааны эцэс дэх сангийн хувьцааны багцын задаргаа




Эх сурвалж: Ард менежмент ҮЦК ХХК

Тайлант хугацаанд Сан нь Монголын Хөрөнгийн Биржид бүртгэлтэй хувьцаанд хөрөнгө оруулалт хийсэн бөгөөд нийтдээ 1.8 тэрбум төгрөгийн үнэт цаасны арилжаа хийж, 14.6 сая төгрөгийн брокерын шимтгэл төлсөн байна. Брокерын шимтгэл нь 0.8% байгаа нь МХБ-ийн арилжаанд оролцогчдын хувьд харьцангуй бага шимтгэл юм. Мөн брокерын шимтгэлийг хувьцааны үнэд шингээн бүртгэж байгаа тул брокерын шимтгэлийн нөлөө нь нэгж эрхийн цэвэр хөрөнгийн үнэлгээнд нөлөөлсөн болно. Хувьцааны багцын хувьд Санхүүгийн секторын 6, Уул уурхайн секторын 1, Хүнсний үйлдвэрлэлийн секторын 1, Тээврийн секторын 1 болон Хөдөө аж ахуйн секторын 2 компанийн хувьцаанаас бүрдсэн байна. Тайлант хугацаанд олон улсын биржүүдэд арилжаалагддаг үнэт цаасанд хөрөнгө оруулалт хийгээгүй бөгөөд энэ нь олон улсын брокерын компанид данс нээхэд тодорхой хугацаа зарцуулж ажилласантай холбоотой юм. Тухайлбал, Сан нь олон улсын брокероор Interactive Brokers-г сонгосон бөгөөд тус компанид данс нээх ажлыг цаг алдалгүй гүйцэтгэсэн боловч тухайн брокер харилцагчаа таних, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх дүрэм, журмыг дагуу Сангийн материалыг хянахад тодорхой цаг хугацаа зарцуулж, 2021 оны 1 сарын 10-ны өдөр Сангийн дансыг нээсэн болно.

Сангийн зардал

Тайлан хугацаанд Сангийн хөрөнгийн үлдэгдэл нь 5,220.9 сая төгрөг байсан бөгөөд зардлын нийт дүн нь 41.7 сая төгрөг болсон байна. Үйл ажиллагаа явуулсан хоног нь 62 бөгөөд зардлын харьцаа нь 0.8% байна. Харин хөрөнгө оруулалтын менежментийн үйлчилгээ болон кастодианы үйлчилгээний шимтгэл нь нийлээд жилийн 2.85% буюу Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 28.1-д заасан хязгаарын хүрээнд байна.

Зардлын задаргаа



Эх сурвалж: Ард менежмент ҮЦК ХХК

Мэргэжлийн үйлчилгээний зардал нь хөндлөнгийн аудитын зардал бол бүртгэлийн үйлчилгээ болон төлбөр тооцооны үйлчилгээ нь сангийн үйл ажиллагаатай холбоотой зардлууд болно.

Сангийн эрсдэлийн үнэлгээ

Тайлант хугацаанд багцын 39.18%-ийг эрсдэлтэй хөрөнгө буюу хувьцаанд байршуулсан бол үлдсэн хэмжээг эрсдэл бага, тогтмол өгөөж бүхий бонд, хадгаламжид байршуулсан байна.

Сангийн өдөр бүрийн NAV-н хөдөлгөөнөөс шинжилбэл эрсдэлийн үзүүлэлтүүд нь дараах байдалтай байна.

Өдрийн NAV хөдөлгөөний тархалт



Өдрийн стандарт хазайлт нь 0.36% бөгөөд жилийн стандарт хазайлт нь 5.7% байна. Ажиглалтын тоо 30 байгаа нь ямарваа нэг статистик дүгнэлт гаргахад хангалтгүй тоо гэдгийг энд дурдах хэрэгтэй. Хэдий ажиглалтын тоо цөөн ч багцын жилийн стандарт хазайлт маш бага буюу 5.7% байгаа нь багцын ихэнх хувийг эрсдэлгүй хөрөнгүүдэд байршуулсантай холбоотой.

НОГДОЛ АШИГ ТАРААХГҮЙ ТУХАЙ ШИЙДВЭР

Үндэсний Хувьчлалын Сан хамтын ХОС-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөл (ТУЗ) нь 2021 оны 2 дугаар сарын 19-ны өдөр эчнээ санал хураалт явуулж, 2020 оны ашгаас ногдол ашиг тараахгүй байх шийдвэр гаргалаа. ТУЗ нь ХОС-ийн нэгж эрхийн танилцуулга болон ногдол ашгийн бодлогын дагуу ногдол ашиг тараахгүй гэж шийдсэн.

НЭГЖ ЭРХИЙН АРИЛЖАА

Үндэсний Хувьчлалын Сангийн нэгж эрхийн хоёрдогч зах зээлийн арилжаа 2020 оны 10 сарын 26-ны өдөр эхэлсэн бөгөөд арилжаа эхлэхэд нэгж эрхийн ханш 115 төгрөгт хүрч, хамгийн өндөр өсөлтийг үзүүлсэн. Энэ нь анх хөрөнгө оруулагчдад санал болгосон 100 төгрөгөөс даруй 15%-иар өссөн үзүүлэлт бөгөөд үүнд нэгж эрхийг худалдаж авах сонирхолтой хөрөнгө оруулагчдын эрэлт өндөр байсан нь голлон нөлөөлсөн билээ. Түүнчлэн энэхүү эрэлт хадгалагдсанаар 2020 оны 12 сарын 31-ний өдөр нэгж эрх 108.68 төгрөгөөр арилжаалагдаж, хаалтын ханш тогтсон.


2020 оны 10 сарын 26-ны өдрөөс 2020 оны 12 сарын сарын 31-ний өдрийн хороонд нийт 321.2 сая төгрөгийн 3.0 сая ширхэг нэгж эрхийн арилжаа явагдсан ба Монголын Хөрөнгийн Биржээр арилжаалагдаж буй идэвхтэй үнэт цааснуудын нэг байв.



2020 ОНЫ ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ

Ковид-19 цар тахал нь бидний болон дэлхийн нийт ард иргэдийн хувьд амьдралын шинэ дадал зуршлыг бий болгож, олон салбарт эрс өөрчлөлт авчирсан нь санхүүгийн зах зээл дээр ажиглагдаж байна. Агаарын тээвэр, үйлдвэрлэл, үйлчилгээ зэрэг олон салбаруудын хувьцааны үнэ ханш уналттай байсан бол технологи, онлайн худалдаа, харилцаа холбоо, түүхий эд болон эм зүйн салбарууд 2020 оны гол ялагчид нь байж чаджээ.

SP500 индекс дэх хувьцаануудын секторын 2020 оны өсөлт



Эх сурвалж: Блүүмбэрг


2020 оны эхний хагаст дэлхийн улс орнууд цар тахалтай тэмцэх зорилгоор мөнгөний хэт зөөлөн бодлого баримталж, төсвийн болон сангийн тэлэх бодлого хэрэгжүүлснээр санхүүгийн зах зээл тогтворжсон. Тэгвэл 2020 оны сүүлийн хагаст Корона вирусийн эсрэг вакцин гарган авсан, АНУ-н ерөнхийлөгчийн

2020 оны эхний хагаст дэлхийн улс орнууд цар тахалтай тэмцэх зорилгоор мөнгөний хэт зөөлөн бодлого баримталж, төсвийн болон сангийн тэлэх бодлого хэрэгжүүлснээр санхүүгийн зах зээл тогтворжсон. Тэгвэл 2020 оны сүүлийн хагаст Корона вирусийн эсрэг вакцин гарган авсан, АНУ-н ерөнхийлөгчийн сонгууль Ж.Байден ялалт байгуулсан зэрэг үйл явдал нь дэлхийн эдийн засгийн хэтийн төлөвийг сайжруулж, ирээдүйд итгэх итгэлийг нэмэгдүүлснээр санхүүгийн зах зээлд өндөр өсөлтийг авчирсан. Жишээ болгон АНУ-н голлох хувьцааны индексүүдийн ханшийн хөдөлгөөнөөс харж болно.



Эх сурвалж: Блүүмбэрг, SP500 болон NASDAQ индекс

Цар тахлын хоёр дахь давлагаа илүү хохиролтой байсан хэдий ч улс орнуудын хэрэгжүүлж буй арга хэмжээнээс хамаарч ихэнх бүс нутгуудад халдварын өсөлт буурах төлөвтэй болж байна.



Эх сурвалж: Блүүмбэрг

Томоохон төв банкнууд мөнгөний хэт зөөлөн бодлого хэрэгжүүлж эдийн засгийг дэмжих оролдлого хийж байгаа нь хүүгийн төвшинг бүх цаг үеийн доод хэмжээнд хүргэв.

	АНУ	БНХАУ	Европийн холбоо	Их Британи	Япон
Бодлогын хүү	0.25%	4.35%	0.00%	0.10%	-0.10%
10 жилийн хугацаатай засгийн газрын бондын өгөөж	0.920%	3.280%	-0.560%	0.270%	0.007%

Эх сурвалж: Блүүмбэрг

Монгол улсын эдийн засгийн хувьд 2020 онд ДНБ дөрөвдүгээр улирлын байдлаар оны өмнө үеэс 5.3%-иар агшсан, улсын инфляц 2.3% болсон нь Монголбанк бодлогын хүүгээ 6%-д хүргэн бууруулж, эдийн засгийг дэмжих бодлого хэрэгжүүлэхэд дөхөм боллоо. Бодлогын хүү түүхэн доод хэмжээнд хүрсэн нь банкнуудын зээл болон хадгаламжийн хүүг огцом бууруулах үндсэн нөхцөл болов.



Хувьцааны зах зээлийн хувьд, 2020 онд Монголын хөрөнгийн биржийн ТОП-20 индекс 19,285.6 төвшинд хүрч хаагдсан нь өмнөх оны мөн үеэс 1.7%-иар буурсан үзүүлэлт байсан хэдий ч цар тахалтай холбоотойгоор оны дунд хүртэл хүчтэй унаад байсан индекс эргэж өссөн эерэг дүр зураг харагдаж байна.





Tel: +976 77404040
Fax: +976 77404041
www.bdo.mn
Zip code: 14230-0059

Room 1502, Level 15
Union Building - B, Unesco Street
Nami Zam - 62, Khoroo - 1
Sukhbaatar District, Ulaanbaatar
Mongolia

Утас: +976 77404040
Факс: +976 77404041
www.bdo.mn
ШНК: 14230-0059

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
1-р хороо, Нарны зам - 62, ЮНЕСКО-гийн
гудамж, ЮНИОН БИЛДИНГ 6 блок
15-р давхар, 1502 тоот

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

“Үндэсний хувьчлалын сан хамтын ХОС” ХХК -ийн Нэгж эрх эзэмшигчдэд

Санхүүгийн тайлангийн аудитын талаарх тайлан

Санал дүгнэлт

“Үндэсний хувьчлалын сан хамтын ХОС” ХХК (“ХОС” гэх)-ийн дараах тайлангуудаас бүрдсэн санхүүгийн тайлангуудад аудит хийлээ:

- 2020 оны 12-р сарын 31-нээрх санхүүгийн байдлын тайлан;
- Энэ өдрөөр тасалбар болсон жилийн ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлангууд; болон
- Нягтлан бодох бүртгэлийн томоохон бодлогуудын хураангуйг агуулсан санхүүгийн тайлангийн тэмдэглэлүүд.

Бидний дүгнэлтээр, хавсаргасан санхүүгийн тайлангууд нь “ХОС”-ийн 2020 оны 12-р сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал, санхүүгийн гүйцэтгэл болон мөнгөн гүйлгээг бүх материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (“СТОУС”) -ын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандарт (“АОУС”) -ын дагуу хийсэн. Эдгээр стандартын дагуу хүлээх үүрэг хариуцлагаа энэ тайлангийнхаа Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх үүрэг хариуцлага гэсэн хэсэгт харуулсан. Бид Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Олон Улсын Стандартын Зөвлөл (“НБЭЗОУСЗ”) -ийн Мэргэжлийн Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Дүрэм болон Монгол улсад мөрдүүлэхээр шаарддаг санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой ёс зүйн шаардлагуудын дагуу “ХОС”-аас хараат бус байсан бөгөөд НБЭЗОУСЗ-ийн дүрэм болон эдгээр ёс зүйн шаардлагын дагуу бусад ёс зүйн үүрэг хариуцлага бүрэн биелүүлсэн болно. Бидний олж авсан аудитын нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтийн үндэслэл болоход хангалттай бөгөөд зохистой гэж бид найдаж байна.

Бусад асуудал

“Үндэсний хувьчлалын сан хамтын ХОС” ХХК-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн санхүүгийн тайлангууд нь Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийгдээгүй байна. Бид сангийн 2019 оны санхүүгийн тайланд аудит, хяналт болон ямар нэгэн горим хэрэгжүүлэхээр тохироогүй тул 2019 оны санхүүгийн тайланд бүхэлд нь ямар нэг баталгаа гаргах эсвэл санал дүгнэлт илэрхийлээгүй болно.

Бусад мэдээлэл

Удирдлага нь бусад мэдээлэлд үүрэг хариуцлага хүлээдэг. Бусад мэдээлэл нь жилийн тайланд орсон мэдээллээс бүрддэг боловч түүнд бидний аудиторын тайлан ордоггүй.

Санхүүгийн тайланд гаргасан бидний дүгнэлт нь бусад мэдээллийг хамардаггүй бөгөөд бид бусад мэдээллийн талаар аливаа баталгаажилтын дүгнэлт гаргахгүй.

Санхүүгийн тайлангийн аудиттайгаа холбогдуулан бидний хүлээх үүрэг хариуцлага бол бусад мэдээллийг уншиж, ингэснээр бусад мэдээлэл нь санхүүгийн тайлан эсвэл аудитаар олж авсан бидний мэдлэг эсвэл өөр хэлбэрээр материаллагаар буруу илэрхийлэгдсэн байж болох эсэх тухай материаллаг үл нийцлийг авч үзэхэд оршдог.

BDO AUDIT LLC, a Mongolian Limited Liability Company, is a member of BDO International Limited, a UK company limited by guarantee, and forms part of the International BDO network of independent member firms.
Монгол Улсын хягаарлагдмал хариуцлагатай компани болох БДО АУДИТ ХХК нь Их Британийн Нэгдсэн Вант Улсын БДО Интернашнл Лимитидийн гишүүн, олон улсын БДО сүлжээний бие даасан гишүүн байгууллагуудын нэг юм.

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН (үргэлжлэл)

Бусад мэдээлэл (үргэлжлэл)

Бид өөрсдийн гүйцэтгэсэн ажил дээрээ суурилан энэхүү бусад мэдээлэл нь материаллаг буруу илэрхийлэлтэй байна гэж дүгнэвэл тухайн бодит байдлыг тайлагнахыг биднээс шаарддаг. Бидэнд ингэж тайлагнах зүйл байхгүй болно.

Санхүүгийн тайланд Удирдлага ба Засаглах удирдлагын хүлээх үүрэг хариуцлага

Санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт ("СТОУС")-ын дагуу бэлтгэж, үнэн зөв толилуулах, болон алдаа юм үү заль мэхнээс үүдэлтэй материаллаг буруу илэрхийллээс ангид санхүүгийн тайлан бэлтгэх боломж бүрдүүлэхэд зайлшгүй шаардлагатай тийм дотоод хяналтыг тодорхойлох нь удирдлагын үүрэг хариуцлага юм.

Санхүүгийн тайланг бэлтгэж байхдаа удирдлага нь "ХОС"-г татан буулгах юм үү үйл ажиллагааг нь зогсоох эсвэл ингэхээс өөр бодит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд удирдлага өөдрөг төсөөллөөр үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх "ХОС"-ийн чадамжийг үнэлж, шаардлагатай бол өөдрөг төсөөлөлтэй холбоотой асуудлуудын талаар тодруулга хийх, нягтлан болох бүртгэлийн өөдрөг төсөөллийн суурийг ашиглах үүрэг хариуцлага хүлээнэ.

Засаглах удирдлага нь "ХОС"-ийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлагатай байна.

Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх үүрэг хариуцлага

Заль мэх эсвэл алдаанаас үүдсэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлангууд нь бүхэлдээ ангид эсэх талаарх үл үндэслэлтэй баталгаажилтыг олж авч, өөрийн санал дүгнэлтийг багтаасан аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм. Үл үндэслэлтэй баталгаажилт нь баталгаажилтын өндөр түвшин боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудитаар оршин байгаа материаллаг алдаа зөрчлийг цаг ямагт илрүүлж байна гэж амласан баталгаа гаргадаггүй.

Алдаа зөрчил нь заль мэхнээс эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд хэрэв тэр нь дангаараа эсвэл нийлэхээрээ санхүүгийн тайланд үндэслэн түүнийг хэрэглэгчдийн гаргах эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллаг тооцогддог.

АОУС-ын дагуу хийсэн аудитын нэг хэсэг байдлаар бид мэргэжлийн шийдэл гарган, аудитын түршид мэргэжлийн үл итгэх үзлийг баримтлан ажилладаг. Бид мөн:

- Заль мэх эсвэл алдааны улмаас санхүүгийн тайлан материаллаг алдаатай илэрхийлэгдэх эрсдэлийг тодорхойлж, түүнийг үнэлэн уг эрсдэлд тохирох аудитын горимыг боловсруулан хэрэгжүүлж, өөрсдийн санал дүгнэлтийн үндэслэл болохуйц хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоог олж авдаг. Заль мэхнээс үүссэн материаллаг алдааг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүссэн материаллаг алдааг илрүүлэхгүй байх эрсдэлээс харьцангуй их байдаг. Учир нь заль мэхэнд хуйвалдаан, баримт бичгийг хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу тайлагнах, дотоод хяналтыг үл ойшоох явдлууд орсон байж болно.
- Компанийн дотоод хяналтын үр ашигт байдлын талаар санал дүгнэлт гаргах зорилгоор биш харин тухайн нөхцөл байдалд тохирох аудитын горимыг боловсруулах зорилгоор аудитад хамаарах дотоод хяналтын талаар ойлголт олж авдаг.
- Удирдлагын ашигласан нягтлан бодох бүртгэлийн бодлогын тохиромжтой байдал, хийсэн нягтлан бодох бүртгэлийн тооцоолол болон холбогдох тодруулгын үл үндэслэлтэй байдлыг үнэлдэг.

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН (үргэлжлэл)

Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх үүрэг хариуцлага (үргэлжлэл)

- Мөн олж авсан аудитын нотолгоонд үндэслэн компанийн тасралтгүйгээр үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ төрүүлэхүйц үйл явдал, нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал байгаа эсэхийг тодорхойлж, нягтлан бодох бүртгэлийн өөдрөг төсөөллийн суурийг удирдлага зохистойгоор хэрэглэсэн эсэхийг дүгнэдэг. Хэрэв бид материаллаг хэмжээний тодорхой бус байдал оршин байна гэж үзвэл аудиторын тайландаа түүнтэй холбоотой санхүүгийн тайлангийн тодруулгад анхаарал хандуулах эсвэл хийсэн тодруулга нь хангалтгүй байна гэж үзвэл аудитын санал дүгнэлтээ өөрчилдөг. Бидний дүгнэлт нь аудиторын тайлан гаргах өдөр хүртэлх олж авсан аудитын нотолгоонд суурилдаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал эсвэл нөхцөлүүд нь компанийг өөдрөг төсөөллөө үргэлжлүүлэхээ зогсооход хүргэх нөлөө үзүүлж болно.
- Тодруулгыг багтаагаад санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулга, бүтэц, агуулга ба санхүүгийн тайлангууд нь үнэн зөв толилуулгын шаардлагыг хангахүйц хэмжээнд гол гол ажил гүйлгээ ба үйл явдлыг илэрхийлсэн эсэхийг үнэлдэг.

Бид аудитын төлөвлөсөн цар хүрээ ба хугацаа, аудитынхаа явцад олж илрүүлсэн дотоод хяналт дахь томоохон зөрчил дутагдлыг оруулаад нөлөө бүхий аудитын илрүүлэлтүүд, бусад асуудлуудаар засаглах эрх бүхий удирдлагатай харилцдаг.

Хууль тогтоомж, зохицуулалтын шаардлагын талаарх тайлан

Бид "Үндэсний хувьчлалын сан хамтын ХОС" ХХК -ийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр тасалбар болсон санхүүгийн жилийн дэлгэрэнгүй орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо болон бусад тайлбар тодруулгуудаас бүрдсэн санхүүгийн тайлангуудад аудит хийж дүгнэлтээ гаргасан.

Бид санхүүгийн тайлангийн аудитыг гүйцэтгэх явцдаа санхүүгийн тайлагналтай холбоотойгоор хөрөнгө оруулалтын сангийн компанид мөрдүүлэхээр зохицуулагч байгуулагаас гаргасан дүрэм, журмын даган мөрдөлтийн талаар тест гүйцэтгэсэн бөгөөд Монгол Улсын хууль тогтоомж, Санхүүгийн зохицуулах хорооны дүрэм, журмыг ноцтойгоор зөрчсөн гэсэн үл үндэслэлтэй нотолгоо бидэнд мэдэгдээгүй.

Тайлангийн хэрэглээ

Энэхүү тайланг Монгол Улсын "Компанийн тухай хууль"-ийн 95.1-р зүйлд заасан хуулийн этгээд болох "Үндэсний хувьчлалын сан хамтын ХОС" ХХК-ийн нэгж эрх эзэмшигчдэд зориулж бэлтгэсэн. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй.



Л. БАЯРЦОГЗОЛ
"БДО Аудит" ХХК
Монгол улс, Улаанбаатар хот
Сүхбаатар дүүрэг, 1-р хороо,
Юнескогийн гудамж, Нарны зам-62
Юнион Бюдинг В блок, 1502 тоот өрөө

Огноо: 2021.03.31

**2020 оны 12-р сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн
Ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайлан**

	Тэм	2020 он мян.төг	2019 он мян.төг
Хүүгийн орлого	6	66,244	559
Ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн анхүүгийн хөрөнгөын бодит үнэ цэнийн өсөлтийн олз	11	225,481	-
Нийт үйл ажиллагааны орлого		291,725	559
ХОМК-ийн үйлчилгээний зардал	7	(21,813)	-
Кастодианы үйлчилгээний зардал	7	(3,045)	-
Бусад зардал	7	(16,883)	(376)
Нийт үйл ажиллагааны зардал		(41,741)	(376)
Татварын өмнөх ашиг		249,984	183
Орлогын албан татварын зардал	8	(29,131)	(56)
Тайлант жилийн ашиг		220,083	127
Нэгж эрхэд ногдох ашиг	9	21.20	0.05

**2020 оны 12-р сарын 31-ний өдрөөр тасалбар болсон
Санхүүгийн байдлын тайлан**

	Тэм	2020.12.31 мян.төг	2019.12.31 мян.төг	2019.08.07 ¹ мян.төг
Хөрөнгө				
Эргэлтийн хөрөнгө				
Ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн санхүүгийн хөрөнгө	11	2,069,774	-	-
Хорогдуулсан өртгөөр хэмжсэн санхүүгийн хөрөнгө	12	2,036,255	-	-
Бусад авлага	10	20,100	40,000	-
Урьдчилж төлсөн төлбөр	13	39,830	31	-
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	14	998,539	210,154	250,000
Нийт эргэлтийн хөрөнгө		5,164,498	250,185	250,000
Эргэлтийн бус хөрөнгө				
Урьдчилж төлсөн төлбөр	13	302,687	-	-
Нийт эргэлтийн бус хөрөнгө		302,687	-	-
Нийт хөрөнгө		5,467,185	250,185	250,000
Өр төлбөр				
Богино хугацаат өр төлбөр				
Худалдааны болон бусад өглөг	15	223,641	2	-
Орлогын татварын өглөг	8	57	56	-
Нийт богино хугацаат өр төлбөр		223,698	58	-
Урт хугацаат өр төлбөр				
Хойшлогдсон татварын өглөг	8	22,507	-	-
Нийт урт хугацаат өр төлбөр		22,507	-	-
Нийт өр төлбөр		246,205	58	-
Цэвэр хөрөнгө				
Хувь нийлүүлсэн хөрөнгө	16	5,000,000	250,000	250,000
Хуримтлагдсан ашиг		220,980	127	-
Нийт цэвэр хөрөнгө		5,220,980	250,127	250,000
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө		5,467,185	250,185	250,000

¹ - ХОС нь 2019 оны 07-р сарын 17-ны өдрийн үүсгэн байгуулагчийн 19/05 тоот шийдвэрээр үүсгэн байгуулагдаж, 2019 оны 08-р сарын 07-ны өдөр Монгол улсын Улсын бүртгэлийн албанд бүртгүүлж эхлэлтийн тайлан гаргасан

**2020 оны 12-р сарын 31-ний өдрөөр тасалбар болсон
Цэвэр хөрөнгийн өөрчлөлтийн тайлан**

	Хувь нийлүүлсэн хөрөнгө мян.төг	Хуримтлагдсан ашиг мян.төг	Нийт өмч мян.төг
2020 оны 01 сарын 01-ний үлдэгдэл	250,000	127	250,127
Тайлант жилийн ашиг	-	220,853	220,853
Тайлант жилийн бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-
Тайлант жилийн нийт дэлгэрэнгүй ашиг	-	220,853	220,853
Гаргасан нэгж эрх	4,750,000	-	4,750,000
2020 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	5,000,000	220,980	5,220,980
2019 оны 08 сарын 07-ны эхлэлтийн тайлан	250,000	-	250,000
Тайлант жилийн ашиг	-	127	127
Тайлант жилийн бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-
Тайлант жилийн нийт дэлгэрэнгүй ашиг	-	127	127
Гаргасан нэгж эрх	-	-	-
2019 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	250,000	127	250,127

**2020 оны 12-р сарын 31-ний өдрөөр тасалбар болсон
Мөнгөн гүйлгээний тайлан**

	Тэм	2020 мян.төг	2019 мян.төг
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ			
Тайлант жилийн ашиг		220,853	127
Тохируулга:			
Бодит үнэ цэн нь ашиг, алдагдлаар илэрхийлэгдсэн хөрөнгө оруулалтын үнэлгээний хэрэгжээгүй олз	11	(225,066)	-
Хүүгийн орлого	6	(66,244)	(559)
Орлогын албан татварын зардал	8	29,131	56
Ажлын капиталын өөрчлөлтийн өмнөх үндсэн үйл ажиллагааны алдагдал		(41,326)	(376)
Бусад авлагын (өсөлт)/бууралт		39,875	(40,000)
Урьдчилж төлсөн төлбөрийн (өсөлт)		(342,486)	(31)
Хөрөнгө оруулалтын (өсөлт)		(3,844,708)	2
Худалдааны болон бусад өглөгийн өсөлт		223,639	-
Үндсэн үйл ажиллагаанд зарцуулсан мөнгө		(3,965,006)	(40,405)
Төлсөн орлогын албан татвар	8	-	-
Хүлээн авсан хүү		3,391	559
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ		(3,961,615)	(39,846)
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ			
Гаргасан нэгж эрх	16	4,750,000	-
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ		4,750,000	-
Тайлант жилд бий болсон/(зарцуулсан) нийт цэвэр мөнгөн гүйлгээ		788,385	(39,846)
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн гадаад валютын ханшийн өөрчлөлтийн нөлөө		-	-
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	14	998,539	210,154

